



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ -ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/1/СТА-ААТҮГ

Цахим хуудас:  
[www.dornogovi@audit.gov.mn](http://www.dornogovi@audit.gov.mn)

Сайншанд сум  
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: [gan-ulziit@audit.gov.mn](mailto:gan-ulziit@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: [Oyuntulkhuur.u@audit.gov.mn](mailto:Oyuntulkhuur.u@audit.gov.mn)

Аудитор: Э.Батчимэг

Утас: 99032916

Цахим хаяг: [ij17.audit@gmail.com](mailto:ij17.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.15 № 1-8/295

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ДОРНОГОВЬ АЙМГИЙН "ЭМ  
ЭРГЭЛТИЙН САН" ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Э.ЭРХЭМБОЛД ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

7/0020532

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр /	
	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31		
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,001,026.73	8,490,738.31		
1.1.2	Дансны авлага	99,259,128.15	80,283,487.14		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	34,090.91			
1.1.6	Бараа материал	233,557,948.31	389,508,190.02		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>335,852,194.10</b>	<b>478,282,415.47</b>		
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
1.2.1	Үндсэн хөрөнгө	96,442,018.46	92,461,619.64		
1.2.2	Биет бус хөрөнгө	6,834,966.67	5,106,148.48		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>103,276,985.13</b>	<b>97,567,768.12</b>		
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>439,129,179.23</b>	<b>575,850,183.59</b>		
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>				
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
2.1.1.1	Дансны өглөг	60,880,465.03	256,966,082.45		
2.1.1.3	Татварын өр	21,134,617.22	25,361,067.61		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,082,915.50			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>83,097,997.75</b>	<b>282,327,150.06</b>		
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>83,097,997.75</b>	<b>282,327,150.06</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>				
2.3.1	Өмч: - төрийн	189,682,669.33	189,682,669.33		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,556,000.00	1,714,000.00		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	164,792,512.15	102,126,364.20		
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	(8,638,284.39)	(62,666,147.95)		
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	173,430,796.54	<b>164,792,512.15</b>		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>356,031,181.48</b>	<b>293,523,033.53</b>		
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>439,129,179.23</b>	<b>575,850,183.59</b>		

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр /

	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,493,915,004.95</b>	<b>1,811,727,658.00</b>
2	Борлуулалтын өртөг	1,026,865,561.38	1,265,864,011.94
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>467,049,443.57</b>	<b>545,863,646.06</b>
5	Хүүний орлого	200,487.00	
8	Бусад орлого	40,691,500.00	17,628,899.68
9	Борлуулалт, маркетингийн зардал	347,303,934.67	437,833,910.75
10	Ерөнхий ба удирдлагын зардал	132,463,231.83	142,811,265.45
12	Бусад зардал	36,812,548.46	45,513,517.49
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(8,638,284.39)</b>	<b>(62,666,147.95)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(8,638,284.39)</b>	<b>(62,666,147.95)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(8,638,284.39)</b>	<b>(62,666,147.95)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(8,638,284.39)</b>	<b>(62,666,147.95)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	2020 оны 12-р сарын 31
1	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>189,682,669.33</b>	<b>1,556,000.00</b>	<b>173,430,796.54</b>	<b>364,669,465.87</b>
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>189,682,669.33</b>	<b>1,556,000.00</b>	<b>173,430,796.54</b>	<b>364,669,465.87</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(8,638,284.39)	<b>(8,638,284.39)</b>
9	<b>2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>189,682,669.33</b>	<b>1,556,000.00</b>	<b>164,792,512.15</b>	<b>356,031,181.48</b>
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>189,682,669.33</b>	<b>1,556,000.00</b>	<b>164,792,512.15</b>	<b>356,031,181.48</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(62,666,147.95)	<b>(62,666,147.95)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого		<b>158,000.00</b>		<b>158,000.00</b>
17	<b>2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>189,682,669.33</b>	<b>1,714,000.00</b>	<b>102,126,364.20</b>	<b>293,523,033.53</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр /	
	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,703,603,181.85</b>	<b>2,042,012,406.48</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,454,544,703.85	1,725,199,373.80
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	208,166,491.00	259,271,012.00
	Татаас, санхүүжилтийн орлого	40,691,500.00	57,454,619.00
	Бусад мөнгөн орлого	200,487.00	87,401.68
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,681,318,608.08</b>	<b>2,028,028,158.53</b>
	Ажиллагчдад төлсөн	345,591,793.90	423,121,421.38
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	44,237,948.88	54,131,461.11
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,135,009,472.52	1,384,124,541.55
	Ашиглалтын зардалд төлсөн	35,002,834.41	55,245,833.73
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,211,951.78	9,486,126.05
	Татварын байгууллагад төлсөн	51,421,573.20	27,649,241.68
	Бусад мөнгөн зарлага	50,843,033.39	74,269,533.03
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>22,284,573.77</b>	<b>13,984,247.95</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>21,822,727.27</b>	<b>8,494,536.37</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,822,727.27	8,494,536.37
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(21,822,727.27)</b>	<b>(8,494,536.37)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>461,846.50</b>	<b>5,489,711.58</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,539,180.23</b>	<b>3,001,026.73</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,001,026.73</b>	<b>8,490,738.31</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	2020 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	<b>Орлого</b>	1,780,000.00	1,811,727.60	(31,727.60)	101.78
	Хүү орлого		87.40	(87.40)	
	Хандивын орлого		17,541.50	(17,541.50)	
	<b>ББӨ</b>	1,085,631.00	1,265,864.00	(180,233.00)	116.60
	<b>Нийт ашиг</b>	<b>694,369.00</b>	<b>563,492.50</b>	<b>148,505.40</b>	<b>81.15</b>
1	Цалин	422,482.50	423,121.40	(638.90)	100.15
2	Шимтгэл	51,521.90	54,131.40	(2,609.50)	105.06
3	5 жилийн урамшуулал	23,761.00	11,290.25	12,470.75	47.52
4	Томилолт	3,500.00	2,196.00	1,304.00	62.74
5	Хангамжийн материал	5,000.00	6,115.90	(1,115.90)	122.32
6	Сэлбэг	2,100.00	2,384.30	(284.30)	113.54
7	Шатахуун	8,000.00	6,877.30	1,122.70	85.97
8	Түлш	4,600.00	3,985.00	615.00	86.63
9	Цахилгаан	8,650.90	10,915.60	(2,264.70)	126.18
10	Бичиг хэрэг	3,300.00	3,867.80	(567.80)	117.21
11	Холбоо	600.00	562.20	37.80	93.70
12	Интернэт	5,100.00	5,245.40	(145.40)	102.85
13	Элэгдлийн зардал	20,000.00	15,652.20	4,347.80	78.26
14	Биет бус хөрөнгийн хорогдуулга	1,732.00	945.00	787.00	54.56
15	Халаалт, цэвэр бохир ус	11,710.50	11,419.40	291.10	97.51
16	Хог хаягдал зөөсөн	192.00	60.00	132.00	31.25
17	Байрны түрээс	19,000.00	18,458.90	541.10	97.15
18	Банкны шимтгэл	5,000.00	8,594.20	(3,594.20)	171.88
19	Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,661.20	1,890.40	(229.20)	113.80
20	Даатгалын зардал	300.00	292.16	7.85	97.39
21	Сумдын унааны зардал	6,400.00	9,567.80	(3,167.80)	149.50
22	Автомашин татвар	120.00	489.60	(369.60)	408.00
23	Газрын төлбөр	40.00	4.80	35.20	12.00
24	Хог хаягдлын татвар	1,100.00	572.00	528.00	52.00
25	Аудитын төлбөр	2,800.00	3,300.00	(500.00)	117.86
26	Компьютер засвар үйлчилгээ	440.00	664.50	(224.50)	151.02
27	Программ шинэчлэлт	400.00	-	400.00	-
28	Гэрээт засвар үйлчилгээний зардал	2,000.00	2,000.00	-	100.00
29	Актлагдсан эмийн зардал	2,000.00	3,895.10	(1,895.10)	194.76

30	Гэрээт үзлэгийн зардал	660.00	-	660.00	-
<b>ҮА-ны зардал дүн</b>		<b>614,172.00</b>	<b>608,498.61</b>	<b>5,673.39</b>	<b>99.08</b>
ҮА бус зардал: Үүнд		-		-	
1	Сургалтын зардал	1,500.00	1,699.20	(199.20)	113.28
2	Ахмадын хороо	900.00	500.00	400.00	55.56
3	Ажилчдад тэтгэмж	2,000.00	1,629.90	370.10	81.50
<b>Бүгд</b>		<b>4,400.00</b>	<b>3,829.10</b>	<b>570.90</b>	<b>87.03</b>
<b>Нийт зардал</b>		<b>618,572.00</b>	<b>612,327.71</b>	<b>6,244.29</b>	<b>98.99</b>
1	Шинэ салбар	75,797.00	13,830.89	61,966.11	18.25
<b>ДҮН</b>		<b>694,369.00</b>	<b>626,158.60</b>	<b>68,210.40</b>	<b>90.18</b>
<b>Ашиг алдагдал</b>		-	<b>(62,666.10)</b>		

### **3.Аудитын тайлан**

---

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Ц.Эрхэмболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага, өглөгийг бууруулах, НӨАТ-ын тайланг сар бүрийн санхүүгийн тайлангаарх борлуулалттай тулгаж хэвших, улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх өөрийн хөрөнгийн дүн санхүүгийн тайлангаас зөрүүтэй байгаа талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 03-наас 2021 оны 03 дугаар сарын 14-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн захирал, Аудитор Э.Батчимэг, Ахлах аудитор Г.Энхтөр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар-т 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 44 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит ж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмч, үүнээс Дорноговь аймгийн ИТХ 100 хувь эзэмшиж байна.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн иргэд, эрүүл мэндийн байгууллагыг Монгол улсын Эмийн бүртгэлд бүртгэгдсэн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт шалгалт, аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна.

Тус хяналт шалгалтаар нийт 230.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 99.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 131.5 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн байна.

Нийт алдаа зөрчлийн 222.3 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, зөрчлийн биелэлт 96,3 хувьтай байгаа нь авлага барагдуулах ажлаас үлдсэн байна.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1,811.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143,84 сая төгрөгөөр буюу 32 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.00	9.01	6.01
Авлага	99.26	80.28	(19.01)
Урьдчилгаа			
Бараа материал	233.56	396.11	162.55
Үндсэн хөрөнгө	103.28	97.57	(5.71)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>439.13</b>	<b>582.97</b>	<b>143.84</b>
Өр төлбөр	83.10	281.99	199.23
Эздийн өмч	356.03	300.98	(55.05)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>439.13</b>	<b>582.97</b>	<b>143.84</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9.01 сая төгрөг болж 6.01 сая төгрөгөөр өссөн нь картаар хийгдсэн борлуулалт дараагийн өдөрт орж ирдэгтэй холбоотойгоор он дамжсан орлогоос шалтгаалсан байна. Энэ нь энэ хэмжээний өр төлбөрийг бууруулах боломжийг хааж байна.

Авлага дансны үлдэгдэл 80.3 сая төгрөг болж 19.0 сая төгрөгөөр буурсан нь Олон-Овоо салбарын эрхлэгч Э.Дөлгөөний төлбөрийг бүрэн барагдуулсан, зарим эд харицагч нар тодорхой хэмжээний төлбөрөө барагдуулсан зэргээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2010-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон 62.3 сая төгрөгийн байгууллагаас 0.5 сая, хувь хүнээс авах 61.8 сая төгрөгийн авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 3.0 сая төгрөгийн авлага байна. Энэ нь тооцоо нийлсэн акт анхан шатны баримтгүй, өмнөх ажиллаж байсан хүмүүстэй холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 396.11 сая төгрөг болж 162.55 сая төгрөгөөр өссөн нь худалдан борлуулах зориулалтаар авсан эм бэлэн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Оны эцэст 200 сая төгрөгийн эм бараа худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь ковид 19 өвчинтэй холбоотой эмийн тасалдал үүсэх, тэг зогсолт, төмөр замын тээшээр эм тээвэрлэхгүй байгаа зэрэг шалтгаантай байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97.7 сая төгрөг болж 5.7 сая төгрөгөөр буурсан нь 2020 онд үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь Орон нутгийн өмчийн газрын балансаас шилжүүлэн өгсөн 3.3 сая, 10 жилийн ойн хандиваар Эм холбооноос үнэ төлбөргүй шилжиж ирсэн 0.5 сая, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 8.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс АИТХ-ын 52 дугаар тогтоолоор 40.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 8.6 сая төгрөг болж 5.3 сая төгрөгөөр буурсан нь цаашид ашиглагдахгүй болсон программ хангамжийг АИТХ-ын 52 дугаар тогтоолоор данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 281.99 сая төгрөг болж 199.23 сая төгрөгөөр өссөн нь эмийн татан авалтаас үүссэн харилцагч нарт өгөх өглөг, татварын өрөө төлж чадаагүй зэргээс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 293.5 сая төгрөг болж 62.5 сая төгрөгөөр буурсан нь алдагдлаас шалтгаалжээ. Үүнд:

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 1.7 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр өссөн нь Алтанширээ сумын эмийн сангийн газар бүртгэснээс шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 102.1 сая төгрөг болж 66.2 сая төгрөгөөр буурсан нь 2020 онд үүссэн алдагдлаас шалтгаалжээ.

### **3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1780.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1780.0 сая төгрөгөөр, ашиг / алдагдал -ыг 0 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээнд 75.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1811.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1892 сая төгрөгийн зардал гарган, 66.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь эм, эмнэлгийн хэрэгсэлтийн борлуулалтаас 100 хувь бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Нийт орлого</b>					
	Үүнээс: Цэвэр борлуулалт	1493.92	1,780.00	1811.73	(31.73)	101.7
<b>2</b>	<b>Нийт зардал</b>					
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1026.87	1,085.63	1265.86	(180.23)	116.6
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	<b>516.58</b>	<b>694.37</b>	<b>626.16</b>	68.2	90.18
	в) Хөрөнгө оруулалт их засвар					
<b>3</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>-8.64</b>	<b>-</b>	<b>-62.67</b>		

Нийт орлогын гүйцэтгэл 1811.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 31.73 сая төгрөг буюу 1.7 хувиар давж биелсэн нь Ковид 19 өвчний 3 сард бүртгэгдсэн анхны тохиолдол, 11 сард үүссэн өвчний дэгдэлттэй холбоотой нэг удаагийн маск, ариутгалын бодис нэг удаагийн хамгаалалтын хэрэгслийн борлуулалт нэмэгдсэн, 11 сараас эхлэн ЭМД-ын хөнгөлөлттэй жорын олголт гүйцэтгэлээр олгож эхэлсэн, мөн эмийн нэр төрлийг зээлээр татан авч нэмэгдүүлэх бодлого барьж ажилласантай холбоотой орлого нэмэгдсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1892.02 сая төгрөг болж, төлөвлөснөөс 112.02 сая төгрөг буюу 6.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисын хомсдолоос шалтгаалан үнэ тооцоолсноос хэт өндөр ирснээр иргэдэд очих төлбөрийн дарамтыг багасган тасалдал үүсгэхгүй байх, үнээ нэмэхгүй байх бодлого барьсан, мөн валютын ханшны өсөлт, тендерийн эмийн тасалдал үүссэн тул зах зээл дээрээс ижил төрлийн эмийг өндөр үнээр авч төлөвлөснөөс бага ашигтайгаар зарсан, мөн 2020 оны 11 сард ЭМД-ын хөнгөлөлтөөр олгогддог эмийн дээд хязгаар өөрчлөгдсөнөөр зарим нэр төрлийн эмийг алдагдалтайгаар борлуулалт хийсэн шалтгаанаар нэмэгдсэн, үндсэн бус үйл ажиллагааны зардал конторын ажилчдын цалинг 12.5 хувиар, салбарын ажилчдын цалинг 8 хувиар нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг/ алдагдал 62.6 сая төгрөг байгаа нь ББӨ 16.6 хувиар нэмэгдсэнээс шалтгаалан үүсч байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, хурлын төлөөлөгч, иргэний төлөөлөгч, ОНӨ-ийн газрын дарга, Нийгмийн бодлого хариуцсан газрын дарга, Нийгмийн бодлого хариуцсан газрын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ба 2020 оны 11 сард ТУЗ дарга солигдсон байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд төсөв баталж зарцуулаагүй байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 25 мэдээллээс 18 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	232.0	1	232.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	8,109.2	1	8,109.2	100
Нийт дүн	2	8,341.2	2	8,341.2	100

/сая.төг/

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

###### **3.1.1 Илрүүлэлт:**

Тайлант онд 80.2 сая төгрөгийн авлага, 282.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

###### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

###### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Өглөг, авлагыг барагдуулж, тооцоог баталгаажуулж ажиллах.,

###### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

2020 онд эмийн нөөц бүрдүүлэх, ковидтай холбоотой эмийн борлуулалт өмнөх жилүүдээс буурсан ба авлагыг 20,0 сая төгрөгөөр бууруулаад байгаа ч ажилчдын төлбөрийн чадвараас шалтгаалаад бүрэн барагдуулж чадаагүй. Цаашдаа өр авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулан, өр төлбөр үүсгэхгүй байхад анхааран ажиллана.

##### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

###### **3.2.1 Илрүүлэлт:**

2020 оны 12 дугаар сарын НӨАТ-н тайлангийн баримт /И-баримт/-ыг хугацаанд нь илгээгээгүй, тайлан засварлах хүсэлт гарган нөхөж тайлагнадаг байна.

Энэ нь үнэлгээ батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нэмэгдсэн өртгийн татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

###### **3.2.2 Эрсдэл:**

НӨАТ-ын тайлангийн дүн гүйлгээ баланс, ерөнхий журналын дүнтэй тохирохгүй байх

###### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

НӨАТ-ын тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

###### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Салбар эмийн сангуудын дутагдалтай холбоотой 12 дугаар сарын НӨАТ-ын тайланд өөрчлөлт орсныг татварын байгууллагад хүсэлт илгээн залруулга хийгдсэн. Цаашид анхаарч ажиллах болно.

### 3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

#### 3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тайлагнасан өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнтэй зөрүүтэй байна.

Энэ нь толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлангаас зөрүүтэй тусгагдсан

#### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Компаний тухай хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх

#### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өмчийн дүн 10 жилийн өмнө байгуулагдсан цагаас өөрчлөлт хийгдээгүй байгаа үнэн. 2021 онд Улсын бүртгэлийн байгууллагад хандан зохих өөрчлөлтийг хийлгэх болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ -ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ДГА-2021/1/СТА-ААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ</b>		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд 80.2 сая төгрөгийн авлагатай, 282.3 сая төгрөгийн өглөгтэй байна	-	Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Эрхэм болд
2	12 дугаар сарын НӨАТ-н баримтыг хугацаанд нь илгээгээгүй, тайлан засварлах хүсэлт гарган нөхөж хийсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Эрхэм болд
3	Санхүүгийн тайланд тайлагнасан өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнтэй зөрүүтэй байна.	12.5	Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Эрхэм болд
<b>ДҮН</b>		<b>12.5</b>			